

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн байцгаана уу,

H1N1 вирусын халдвар авагчдын тоо нэмэгдэж байгаа энэ үед ОУДС-ийн хамт олон бид сурагчиддаа чанартай боловсрол эзэмшүүлэхээр ажиллаж байгаа биднийг ойлгож хүлээцтэй хандаж байгаад та бүхэнд талархал илэрхийлье. H1N1 вирусын тархалтын талаар бид өдөр бүр шинэ мэдээлэл авсаар байна.

Бидэнд өөрсдийн шугамаар олж авсан мэдээллээ ирүүлж байгаа эцэг эхчүүддээ баярлалаа. Бид SOS клиник болон эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбоотой байж CDC вэбсайтыг тогтмол шалгаж байна.

Бид та бүхэнд аль болох түргэн хугацаанд мэдээлэл хүргэж байх болно.

Бид та бүхэнд сургуулиас санал асуулгын вэб сайтыг дурдсан e-мэйл явуулсан. Энэхүү санал асуулгыг та бүхэн 11 сарын 6-ны 12 цагаас өмнө бөглөнө үү. Та бүхний хариулт ОУДС-ийн багш ажилтнууд, Удирдах Зөвлөлийн гишүүд болон сургуулийн удирдлагуудад сургуулийн цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход тус болох юм.

Сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх мэргэжилтэн манай сургууль дээр 11 сарын 11, 12-нд ирж ажиллаж сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдэд нэг өдрийн сургалт явуулна. Удирдлагын сайн зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд бид жил бүр сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдэд болон удирдлагын багийг ханд зориулж сургалт явуулдаг уламжлалтай.

Та бүхэн амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй.

**Захирал Greg Rayl**

### **Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,**

H1N1 вирусээр үүсгэгдсэн халдвараас сэргийлэх талаар сургууль мэргэжлийн байгууллагуудтай байнга холбоотой байж сүүлийн үеийн мэдээ мэдээлэл тогтмол авч байна.

Халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс бид ариун цэвэр сахих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

- Бүх ангиудад бактерийн эсрэг гар ариутгагчийг багш сурагчид хэрэглэж байна
- Өдөр бүр хаалганы бариул, ширээ сандлын тавцангуудыг халдваргүйжүүлэх уусмалаар тогтмол 3 удаа цэвэрлэж байна
- Бие засах өрөөнүүдийг халдваргүйжүүлэх шингэн уусмалаар сайтар цэвэрлэж байна
- Сургуулийн сувилагч Эрүүл Мэндийн Яамнаас гаргасан зөвлөмжийн дагуу ариун цэврийг тогтмол шалгаж багш сурагчдад зөвлөгөө өгч байна
- Багш нар сурагчдын гарыг хоол идэхийн өмнө болон бие зассаны дараа тогтмол угаалгаж, сурагчдад шингэн юм уулгаж витамин ууж бусадтай усны саваа хуваалцахгүй байхыг анхааруулж байна
- Ханиадын шинж тэмдэг илэрсэн багш, сурагчдыг тэр даруй гэр лүү нь явуулах арга хэмжээг авч байна

Эцэг эхчүүд та бүхэн халдвараас сэргийлэх дээрх арга хэмжээг гэрт нь сурагчдад тогтмол хэвшүүлээрэй. Та бүхэн өглөө бүр сурагчдыг хичээлд явахад нь биеийн байдлыг нь шалгаж халуунтай буюу бөөлжих шинж тэмдэг байвал гэрт нь үлдээж шингэн юм сайн уулгаж эмнэлэгт хандаарай.

**Дэд Захирал  
Арилдий Туул**

## ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

2-р улирлын хичээлдээ тавтай морилно уу. Та бүхэн намрын амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт би итгэлтэй байна. Би амралтаараа Говь руу аялсандаа баяртай байна. Та бүхнийг энэ сайхан газар очиж үзээрэй гэж зөвлөж байна.

Цаг агаар улам хүйтэрч байгаатай уялдуулан би та бүхнийг дулаан хувцаслаж, сайн унтаж амарч, ус их уухыг зөвлөж байна. Ажил амралт, хоол ундаа зөв зохицуулж бие мах бодоо эрүүл чийрэг байхад нь туслаарай.

2-р улирал эхэлж байгаа тул сурагчид маань энэ улиралд үзэх шинэ хичээл, сэдвийнхээ талаар та бүхэнд танилцуулах байх аа. Эцэг эх багш нарын хурал 11 сарын 10-нд болно. Энэ өдөр та бүхэн хүүхэдтэйгээ сургууль дээр хүрэлцэн ирж багш нартай нь уулзаж ярилцаарай. Бид бүхэн та нартай уулзаж хүүхдийн тань сурлагын талаар та бүхэнтэй ярилцах цаг зав гаргах болно.

Дунд Сургуулийн Эрхлэгч  
Betsy Hanselmann

## БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Би та бүхнийг намрын амралтаа сайхан өнгөрүүлсэн гэж найдаж байна.

**Өдөрлөг:** 2-р ангийн сурагчид үзсэн хичээлийн сэдвийн дагуу өөрсдийн хийсэн загвар байшингуудыг бидэнд танилцуулаа. Сурагчид хоёр хоёроороо хамтарч их сонирхолтой, өвөрмөц хэлбэрээр загварын байшингуудыг хийж чимэглэсэн байлаа. Өдөрлөгт бэлтгэж тэд өөрсдийн ярих чадварыг болон компьютер дээр бичих чадвараа бас дасгалжуулсан юм. 2-р ангийн сурагчиддаа баяр хүргэе.

Олон сурагчид **Halloween**-өдөрт зориулсан костюм өмсөж ангидаа олон арга хэмжээ зохион байгууллаа. Spooky Story уралдаан зарласан 3-р ангийн сурагчиддаа баярлалаа.

11 сарын 10-ны Мягмар гарагт Эцэг Эх Багш нарын хурал болно. Бага сургуулийн эцэг эхчүүд энэ хурлын цагийг авсан байгаа. Энэ өдөр сурагчдын хичээл орохгүй харин багш нар эцэг эхчүүд та бүхэнтэй уулзаж ярилцах болно.

Бага Сургуулийн Эрхлэгч  
Jan Wiggins

## ЭБЗ

ЭБЗ-ийн хурал 11 сарын 3-ны Мягмар гарагт 3 цагаас номын санд болно.

11 сарын 13-ны Баасан гарагт Асуулт Хариултын тэмцээн болно.